

МОНГОЛ ХҮНИЙ ХОЧ НЭРИЙГ УТГА, ХЭВ ШИНЖЭЭР НЬ АНГИЛАВАЛ

Р.Нямцэрэн, доктор

БХ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга

Резюме: Нами выявлены следующие особенности прозвищ: 1. Прозвище – это неофициальное, приобретенное имя реального индивида, показавшего себя в жизни, в коллективе. 2. Существование прозвищ является универсальным явлением в монгольском языке. 3. Прозвище содержит в себе те или иные информации об именуемом человеке. 4. Прозвище есть динамическое языковое явление, которое изменяется с соответствии с изменениями как в жизни данного индивида, так и в социально-культурной жизни всего общества в целом. 5. Прозвище отражает собой познавательные, мыслительные и социально-культурные особенности данного народа.

Прозвище разговорного стиля может иметь прямое и переносное значение. В зависимости от эмоциональных чувств и оценки, выражаемых автором, прозвища разговорного стиля могут выражать оттенки любви, ласки, иронии, ехидства, одобрения, подшучивания, отвращения и т.д.

Түлхүүр үг: Үгийн утга, шууд утга, шилжсэн утга, их нэр, үнэлэмж, баймж чанар

Удиртгал

Оноосон нэр судлалын нэгэн чухал салбар болох хүний нэр судлалд “хоч нэр”-ийн тухай асуудал чухал байр суурийг эзэлдэг байна. Эрдэмтэн Н.Нансалмаа “Хэлийг хүнтэй нь холбож судлах болсон хэлшинжлэлийн хүн төвтэй хандлага голлож буй өнөө үед амьд ярианы нэгэн чухал баялаг хэрэглэгдэхүүн болох хүний хоч нэрийн судалгаа анхаарлын гадна үлдэх ёсгүй” гэж дурдсан байдаг (Нансалмаа, 2011). Хоч нэрийн судлал хэлшинжлэлийн

бусад салбартай харьцуулахад харьцангуй бага судлагдсан, цаашид гүнзгийрүүлэн судлах олон асуудал байсаар байна.

Бид Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ, Архангай, Булган, Хөвсгөл, Увс, Завхан, Говь-Алтай, Ховд, Өвөрхангай, Дундговь, Баянхонгор, Төв аймгийн иргэдийн аман ярианы эх сурвалжаас түүвэр судалгаагаар авсан 6000 орчим хүний хоч нэр (давхардаагүй тоогоор 1536 хоч нэр) бүртгэсэн бөгөөд энэхүү судалгааны хэрэглэгдэхүүндээ үндэслэн хоч нэрийг утга, хэв шинжээр нь ангилж байна.

Үг өөрөө утга зүйн олон махбодийг агуулсан байдаг. Үгийг нэрлүүлж буй юм, үзэгдэлтэй холбогдох харьцааны шинжээс үндэслэн шууд утгатай буюу шилжсэн утгатай, тодорхой утгатай буюу хийсвэр утгатай гэх мэтээр ангилж болно. Аливаа юмыг шууд заан хэлсээр ирсэн жинхэнэ утга нь тэр үгийн шууд утга нь болно. Харин уул үгийг хэрэглэх явцад аль нэгэн төсөөтэй шинжээр нь утга тохоон хэрэглэсэн нь шилжсэн утга болно.

Утга зүйн бүтцийн энэхүү онолын асуудлыг үндэслэл болгон хоч нэрийг утгын хувьд ангилж болох юм. Бидний судалгааны санд байгаа аман ярианы хоч нэр нь шууд ба шилжсэн гэсэн хоёр утгатай байна.

Тухайлбал, Алаг Батбаяр, Арзгар Адьаа, Бүдүүн Мөнхөө, Буржгар Цэлмэг, Бүлцэн Жагдал, Дальжгар Өлзий, Гооргор Төвшөө, Дорвоон Болдоо, Зүүлэг Аюуш, Майжиг Жагаа, Ногоон Ойдов, Өмөлздөг Цэвээнсүрэн, Өрвөлздөг Догоо, Пагдгар Хаянаа, Саагаа Балжаа, Сөөвгөр Шагай,



Тунтүү улаан Батболд, Улаан Тамираа, Ховч Ариунаа, Хэрсүү Цэвэг, Хэрүүлч Бумаа, Хялар Энхээ, Цоз (цондгор) Ганбаа, Цоохор Цэгмид, Шударга Самбуу, Шунал Жолоо гэх мэт хоч нэр нь тухайн хүний бие эрхтний онцлог, гэгэг согог, ааш араншинг нь шууд заан нэрлэсэн утгатай байна.

Харин Амбий (Заяа), Гоймонбаатар, Өндөр Гонгор, Адасга, Туужууран толгойт, Гөөхий, Азарга Ганаа, Бух Агваанаа, Бэлтрэг Бумаа, Гөлөг Дэмбэрэл, Дэрс Сүнжээ, Хожуул Дондог, Хамхуул Ванчигсүрэн гэх мэт хоч нэрс нь олны танил, алдартай хүмүүс, кино, зохиолын баатар, аливаа юм, үзэгдэл, амьтан, ургамалтай адил төстэй шинжээр нь зүйрлэж өгсөн шилжсэн утгатай байна.

Эрдэмтэн Н.Нансалмаа “Шилжсэн утгатай үгэнд бодит ба хийсвэр утгын талыг ялгах шаардлага гардаг. Үгийн утгын юм, үзэгдлийн тухай ойлголтыг агуулсан махбодийг Бодит буюу denotatum, сэтгэл хөдлөл, баймжийг илэрхийлсэн махбодийг Хийсвэр буюу connotatum гэнэ”, “Үгийн шууд утга нэг денотаттай байхад, шилжсэн утга хоёр денотаттай байх ба эл хоёрын нэг нь өөрийнх нь, нөгөө нь шууд утгын денотат байна. Утга шилжсэн нэр буюу яруу зүйрлэл нь үгийн шууд утгатай зайлшгүй холбоотой байж энэ холбоо нь үгийн шууд утгын бодит утга (денотат) шилжсэн утгад дотоод хэлбэрээр илэрч, тэдгээрийг холбож байгаа шинжийг заадаг” хэмээжээ (Нансалмаа, 1997, х. 13, 52).

Ер бодитойгоор оршин байгаа хүн, амьтан, ургамал, юм үзэгдлийн тодорхой шинжийг ажигласны үр дүнд адил төстэй талыг нь үндэслэн зүйрлэж, тэдний нэрээр хочлон нэрлэдэг байна. Судлаач Б.Даваасүрэн “Зүйрлэлийн утгын бүтцэд задаргаа хийж үзэхэд нэрлэх үүрэг бүхий бодит утгын хэсэг нь гол үүрэг гүйцэтгэх бус, харин хүний сэтгэл хөдлөл, хандлага, үнэлэмж илэрхийлэх хийсвэр утгын хэсэг нь гол үүрэг гүйцэтгэдэг. Сэтгэлийн хөдөлгөөн илэрхийлдэг хэлний нэгжүүд зүйрлэлд дээд зэргээр өртсөн байдаг тухай судлаачид тэмдэглэсэн байдаг (Апресян Ю.Д, Джонсон М, Артюнова Н.Д). Энэ нь

хүний харилцаа сэтгэл хөдлөл, хандлага, үнэлэмж илэрхийлэх үүрэгтэй байдагтай холбоотой бөгөөд бодит ертөнцийн ялгаатай юм, үзэгдлийн хоорондын адил төсөөтэй байдлыг олж ажиглах буюу зарим тохиолдолд тийм байдлыг бий болгон харж чадах хүний чадамжтай холбоотой” хэмээжээ (Даваасүрэн, 2009, х.12).

Ийм учраас хоч нэр нь сэтгэл хөдлөл, хандлага, үнэлэмжээсээ шалтгаалж хайрлаж өхөөрдсөн, ёжилж егөөдсөн, сайшаасан, шоглож шоодсон, жигшиж зэвүүцсэн зэрэг олон утгатай байна.

Өхөөрдсөн утгатай хоч нэр. Ангаахай, Бамбарууш Цэндээ, Бондоолой, Божин бор, Ботго Шүрээ, Бөмбүүлэй, Бумбагар, Буржсаак шар, Бүдүүка, Бүлтүүш, Дэлдэн шар, Зулзага, Ишиг Алтанцэцэг, Жоохноо, Можиг, Мондог, Мики, Мики маус, Огдоолой, Үнхэлцэг, Халздай, Хорголжин, Хумбага, Цунцуу, Цоохондой, Ход ход, Шонхоорой, Өнгөт мисс, Эрх шар гэх мэт хоч нэр байгаа бөгөөд голдуу багад нь эцэг эх, эмээ өвөө, хамаатан саднаас нь хайрласан энхэр багын хоч нэр нь өхөөрдсөн утгатай байна гэж үзлээ.

Ёжилж, егөөдсөн утгатай хоч нэр. Банди (охин дүү), Бүдүүн Аюур (Хорчийсон туранхай биетэй), Маль цагаан (Нэр нь Гантөмөр, туранхай хар хүн), Тагш Аагий (архичин), Туяхан согооноо (Нэр нь Туяа, том биетэй, тарган нэгэн), Ширэндэв Цогоо (Ичихийг мэдэхгүй ширэн нүүртэй, архинд дэвтэй) гэх мэтээр ёжилж егөөдсөн утгатай хоч нэр байна. Энэ нь монголчуудын шогч, наргианч зан үйлийн илрэл юм.

Сайшаасан утгатай хоч нэр. Даруухан цагаан (Шинэцэцэг), Дипломат Алагаа (боловсон харьцаатай хүүхэд), Донж Дулмаа (донжийг нь олж хувцасладаг), Мундаг Наваан, Нямбайцагаан (Сарангэрэл), Шударга Самбуу гэх мэтээр голдуу тухайн хүний зан авир, үзэл суртлын бусдаас давах сайн чанараар нь өгсөн хоч нэр сайшаасан утгатай байна.

Шоглож, шоодсон утгатай хоч

нэр. Далбин шар (Гансүх), Мондгой хамарт (Бат-Ирээдүй), Навчин чихт Мөнхсайхан, Өнхрүүш Пүүжээ, Прожсектор (Батжаргал), Сорлог Сүнжээ (үсээ сорлож будсанаас), Сумтай ака (уур уцаар ихтэй), Туужуур толгойт Пүрэвдагва (үсээ засдаггүй, самнадаггүй) гэх мэтээр бие, эрхтэн, зан аашаар нь шоглож өгсөн хоч нэр байна. Хоч нэрийг утга, хэв шинжээр нь дараах байдлаар нарийвчлан ангилж болох юм.

1. Гадаад төрх байдалтай холбоотой хоч нэр

- Шууд заан нэрлэсэн хоч нэр: Алаг нүдэн, Арзгар, Бөгтөр, Бүдүүнээ, Бүлтэн, Ганган, Гулзгай, Данхар, Далиу, Дарвагар, Доголон, Дорвоон, Дутуу, Дух, Дэгжин, Маажиг, Монхор, Мэнгэт, Мээтэн, Навсгар, Нахиу, Нугдгар, Онигор, Оцон, Өргөн, Өндөр, Сартгар, Улаанаа, Улцан, Урт гарт, Үрчгэр, Хазгар, Халзан, Хамар, Хожгор, Хув шар, Цоохор, Чихэн чинээ хүү, Чөргөр, Шанган, Шарка, Шаамий, Шөвгөр, Эрүү, Ярзгар гэх мэт) гэх мэт хоч нэр байгаа юм.
- Шилжсэн утгатай хоч нэр
 - Хүнтэй зүйрлэсэн хоч нэр (Амбий, Ааяа, Ленин, Өндөр Гонгор, Гоймон баатар гэх мэтээр олны танил хүнтэй, Даамбий, Дональд, Жери, Каралсон, Ким Дун Хан, Кү Унже, Отелла, Өвгөн Басел, Соном өвгөн, Ягаан Гажид гэх мэтээр киноны баатруудтай)
 - Юм, үзэгдэлтэй зүйрлэсэн хоч нэр (Бөмбөг, Бууз, Мантуу, Данбоали, Асга хад, Барзгар арав, Никель, Бүрхээр, Торх, Гэлийн тамга, Буруу харсан бундан, Прожсектор, Гэрлэн дохио, Чийдэн, Камаз, Нүүрс, Өндөг, Поошиг, Гоймон, Саваа, Суран хар, Шүдэнз, Шалны мод, Шонгийн мод, Яндан, Салхи, Шуурга гэх мэт)
 - Амьтантай зүйрлэсэн хоч нэр (Азарга, Алмас, Анааш, Баавгай, Болжмор, Борлон, Боохой, Ботго, Буур, Бүргэд, Бяруу, Галуу, Гахай, Голио, Гөлөг, Гөлчгий, Гутиар, Диназавар, Жараахай, Загас, Зараа, Зулзага, Илжиг, Ирвэс,

Ишиг, Мазаалай, Мангас, Матар, Монголын шар, Мөөг, Мөндөл, Муур, Огдоолой, Оготно, Ортоом, Сарлаг, Сармагчин, Согоо, Тарган гахай, Тарвага, Тоорой, Турлиах, Тогоруу, Тэмээ, Тэмээн хяруул, Тэмээлзгэнэ, Улаан үхэр, Ухна, Үхэр, Хайнаг, Хув ямаа, Хулгана, Хурга, Хүн хар гөрөөс, Цагаан баавгай, Цоохондой, Чоно, Шар муур, Шимпанзе, Шумуул, Элээ, Ялаа, Ямаа, Янзага гэх мэт)

- Ургамалтай зүйрлэсэн хоч нэр (Газрын бэтэг, Лооль, Лууван, Манжин толгойт, Дэрс, Мөөг, Сонгино, Сондуул, Хурган цагаан мөөг, Шаваг гэх мэт)

2. Зан авиртай холбоотой хоч нэр

- Шууд заан нэрлэсэн хоч нэр (Агсан Дамбий, Адгуу Хорлоо, Балай Энхнаран, Барьцгүй Тогоо, Бурдаг Жамъян, Бүлт Гэрлээ, Годгор Сараа, Зүүлэг Аюуш, Ичимхий бор, Манараа Довдон, Мангар Дамдин, Мангар хар, Мулгуу Түвдэн, Мурьдаг Төвшөө, Ноомой Шагдар, Онгиороо Оч-Эрдэнэ, Орон гаран Өлзий, Пэд Чука, Саагаа Балжаа, Савчуур Тунгаа, Сагсуу Болдоо, Уймраа Дондов, Хаагаа Баяраа, Хаадгар Молом, Хаалай Сүхээ, Хадуурдаг Цэрэнхүү, Халмаг Рэнцэн, Хөөрүү Баяраа, Цөлх Дорлиг гэх мэт)
- Шилжсэн утгатай хоч нэр
 - Хүнтэй зүйрлэсэн хоч нэр (Дипломат Алагаа, Цэдэнбал /Цэрэннадмид/, Дарга, Салхи Дамбий /Дамдин/)
 - Юм, үзэгдэлтэй зүйрлэсэн хоч нэр (Адасга, Бууны нохой Урнаа, Гранат Дууяа, Овгор Өлзий, Гучин сумтай ака, Жамаараа яваа ертөни, Коммунист Сараа, Нойтон хамуу /Сарангэрэл/, Салхи Дамбий, Тив алгасдаг пуужин, Түнэр харанхуй, Хааз Галаа, Цагаан хоолой, Чихгүй толгой, Шрупп Тэмүүжин,
 - Амьтантай зүйрлэсэн хоч нэр (Азарга Ганаа, Бух Агваанбаяр, Годрон Бүжидням, Гөлөг Дэмбэрэл, Илжиг Батаа, Сарлаг Балжинням, Сармагчин



Ууганбаяр, Тоть Өлзий, Үнэг Долзоо, Хачиг Луузан, Хонь Түмэнжаргал, Шалз Эрдэнэ, Шиманус, Шулмас Аагий,

- Ургамалтай зүйрлэсэн хоч нэр (Хамхуул Ванчигсүрэн)

3. Их нэрээс нь үүтгэн өгсөн хоч нэр

- Их нэрийн утга дагуулж өгсөн хоч нэр (Далавч – Алтанжигүүр, Балгас - Хаш-Эрдэнэ, Банз - Хаш-Эрдэнэ, Ламп – Гэрлээ, Малын хашаа – Хаш, Морины уяа - Бат-Уяа, Хүн ч юм шиг, биш ч юм шиг – Нэргүй, Түргэн зовлон – Удаанжаргал, Хашааны банз - Хаш-Эрдэнэ, Хонгорзул - Хонгор морь, Хөгишин хар – Идэрцагаан, Хуучин билэг – Шинэбилэг, Шатсан гэрэл – Гэрлээ, Шидмэс- Бат-Уяа, Ядуу хар - Баянцагаан гэх мэт)

- Их нэрийн аялга дагуулж өгсөн хоч нэр (Атангаа - Амартүвшин, Баас - Барсбаатар, Бясаа - Баясаа, Гаанс - Ганбаа, Ганжин - Ганжигүүр, Дондог өвөө - Дондог, Доширок – Дашидорж, Жамц давс - Жавзандулам, Жаран мөнгөний печень - Жаргалмаа, Жаран хөлт - Жавзанпагма, Ишиг - Хишигдаваа, Лам - Лхамноржмаа, Мөөхий - Мөөгий, Мөөгөн хаан - Мөнх-Эрдэнэ, Мөөхий - Мөнхболд, Мөхөөлдөс - Мөнх-Эрдэнэ, Нэртэй – Нэргүй, Нялцагдорж - Нацагдорж, Ямаа - Нямаа, Пудрь - Пүрэвдолгор, Пуужин - Цэрэнпунцаг, Пүнтүүз - Пүүжээ, Саланжаргал - Сайнжаргал, Сампин – Самбуу, Самхай - Намхай, Содномцэцэг - Сономжамц, Тоорцог - Тогмоо, Тугал - Туваанаа, Тугал - Тулга, Яран санаа - Урансанаа, Ишиг - Хишигдэлгэр, Хорголмаа – Оргилмаа, Хулгана тамир – Булгантамир, Цэлцэг - Цэнд-Аюуш, Шавж – Шагж, Ямаа – Нямсүрэн, Ямбиймолон – Жамбиймолон гэх мэт

- Их нэрийн утга, аялгаас үүтгэн өгсөн хоч нэр (Бидний судалгааны “Уг хочоор нэрлэх болсон шалтгаан” гэсэн асуултад ихэнх тохиолдолд нэрээр нь, цөөн хоч нэрийн ард тухайлбал, Гэрлээ (Шатсан гэрэл) “нэрээр нь, хараа муутай”; Жавзанпагма (Жавжинпагма) “нэрээр нь, шаамий”; Намхай (Самхай) “нэрээр нь, амаа угаадаггүй”; Булгантамир (Хулганатамир) “нэрээр нь, хулгана шиг

жигжигхэн”, Жавзанпагма (Жаран хөлт) “нэрээр нь бас удаан”)

4. Тохиолдсон явдал, хэлдэг (хэлсэн) үгтэй холбоотой хоч нэр

- Тохиолдсон явдалтай холбоотой хоч нэр (Тухайлбал, Архангай аймгийн Эрдэнэбулган сумын харьяат Хуягаа гэгч жолооч Арслан хочтой. Аймгийн төв музейн үүдний арсланг машинаараа мөргөснөөс Арслан хэмээн хочлогдох болсон. Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын харьяат Туяа гэдэг эмэгтэй гэрийн нь гадаа хүмүүс зодолдоход хоол бэлтгэж байсан балиусаа бариад дунд нь гүйж явснаас Балиус гэсэн хоч нэр авсан байдаг.

Орхон аймгийн Төмрөө хэмээх хүү эгчийнхээ оёж өгсөн майкыг найзууддаа гайхуулснаас Гар майк гэдэг хочтой болсон.

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын харьяат Нямдорж гэгч залуу найзуудтайгаа зогсож байгаад “Манай авгай улаан цамцтай, хашааны цаанаас ирж явна” гэтэл хашааны цаанаас үнээ гараад ирснээс Үнээ хэмээн хочлогдох болсон.

Өвөрхангай аймгийн Уянга сумын Даваа гэдэг залуу худал яриандаа хадуураад онгоц бугуйлдсан гэж ярьснаас Онгоц бугуйлддаг гэсэн хоч авчээ.

Архангай аймгийн МАХН-ын хорооны нарийн бичгийн дарга асан Галдан социализмын үед архитай тэмцэх ажлын хүрээнд, тогоо нэрэхийг зогсоохоор айлуудын бүрхээрийг хурааж, устгах ажил хийснээс Бүрхээр хэмээх хоч зүүж, Гунаажав гэгч хүн нас хязгаарлахгүй сургуульд сургадаг байсан үед 4-р анги төгсөөд эхнэр авсан учир хэн нэг нь “Эр хүн” гэж хэлснээс ийнхүү хочлогдож, насан туршид нь хочлох болжээ.

Луу Дагдан - Хэтрүү яриандаа автаад “Эмнэг луу” чихдэж байсан тухайгаа ярьж хөгөө тарьснаас луу хочтой болсон гэдэг яриа байдаг.

Улсын аварга Жамъян жин тээж явахдаа цөмөрсөн гүүр рүү унасан ачаатай тэмээг

бөгснөөс нь өргөж гаргаснаар Буур Жамъян гэж олноо алдаршсан юм.

- Хэлдэг (хэлсэн) үгтэй холбоотой хоч нэр (Тухайн хүний байнга хэлдэг “амны уншлага болсон” үг болоод санамсаргүй байдлаар ганц нэг удаа хэлсэн үгээс нь үүтгэн хочлон нэрлэх ёс монгол хэлэнд бий. *Гоё Дагваа* (бүх юмыг гоё гэдэг, дүү нар нь гоё ах гэж дууддаг. Энэ нь нэр цээрлэх ёстой холбоотой байна), *Дандаа сайхан Дамчаа* (дандаа сайхан байна гэдэг) гэх мэт цөөн хоч нэрээр тухайн хүнийхээ хэлдэг үгээр нь хочлон нэрлэхдээ хүндэтгэх, бахархах өнгө аясыг илэрхийлсэн байдаг. Гэхдээ хэлдэг (хэлсэн) үгтэй нь холбоотой хоч нэрийн ихэнх нь *шоглож шоодох өнгө аясыг илэрхийлсэн байна*. *Тухайлбал, Ай даа Хүрэл, Бурхан* Буяа (байнга хэлдэг үг нь Бурхан), *За болно, боль* – Долгормаа, *Зангаза Батаа* (занзгар байна гэдэг), *Иш хөөрхий* – Думаа, *Лаа лаа* Равдан, *Лай Батсайхан, Лайл Бужаа* (юм болгоныг “лай л байна” гэдэг), *Унтах надо, Хөөрхий Нацаг, Хэн мэдхэв* – Должин, *Чойрын богд* – Амраа, *Чухалаа* (Хамгийн чухал нь гэж ярьдаг), *Яам Солонгоо* (Оо орохоо ингэж хэлдэг), *Будаа* Сандаг (юм болгоныг будаа болгосон гэж ярьдаг), *Барак Обамагийн гэргий* – *Сэлэнгээ* (асар их нэр хүндтэй хүний эхнэр болно гэж ярьдгаас) гэх мэтээр байнга хэлдэг үг хэллэгээр нь, *Нэг бууз* Гансүх (бөөнөөрөө гуанзанд ороод нэг бууз авъя гэсэн), *Оросын ногоон* Баярмаа (долларыг оросынх гэснээс) гэх мэт нэг удаагийн санамсаргүй байдлаар хэлсэн үгээр нь өгсөн хоч нэр байдаг.

Тэр ч байтугай байнга хэлдэг хараалын үгээр нь *Хөсрий Тогоо, Хуц Төмөрбаатар, Яатуу Болд, Цахирын өгөрүүд, Хүрэмийн хүүрүүд* гэх мэтээр хочлон нэрлэсэн нь жигшиж зэвүүцсэн өнгө аястай байна.

Мөн Архичин болжмор – Жавхлантөгс (архи уугаад согтохоороо “Архичин болжмор жив жив, Архиа нэхээд жив жив” гэж дуулдаг), *Лонхон цэцэг* (архи уухаараа “Хонхон цэцэг” дууг дуулдаг) гэх мэтээр дуулдаг дуугаар нь хочлон нэрлэсэн байдаг)

5. Дадал зуршил, хобби, чадвартай нь

холбоотой хоч нэр

- Дадал зуршил, хоббитой холбоотой хоч нэр

Хүний амьдралын хэвшлээс тогтсон дадал зуршлаар нь өгсөн хоч нэр нэлээд байна. Тухайлбал, хөнгөн хийсвэрээр амьдардаг, буудлаарих хонодог *нэгнийг Буудал Агваанаа*, гэрт орондоо ирдэггүй, тэнэмэл нэгнийг *Хангал Оюунаа, байнга* даалуу тоглож суудаг, хийх ажилгүй, даалуунд донтсон нэгнийг *Даалуу Дорлиг, багаасаа тамхи татсан зуршлаар нь Мохоор* Түдэв, тамхины окурк түүж татдаг *хүүхдийг Окурк Ганаа*, уурын зуух ажиллаж байгаа юм шиг байнга тамхи татаж, утаа баагиулж явдаг нэгнийг *Уурын зуух Батдорж*, архи их хэмжээгээр уудаг нэгнийг *Лонх Нацгаа, Тагш Аагий*, архинд дэвтэй, ичихийг мэдэхгүй ширэн нүүрлэж архи нэхэж уудаг нэгнийг *Ширэндэв Цогоо*, гоёх, чимэг зүүлт зүүх хоббитой, машин нь ёлк шиг чимэглэлтэй нэгнийг *Ёлк Бумаа*, юм л бол бухимдаж, сигналдаж байдаг нэгнийг *Сигнал Цэвээн*, уруу газар бүрт машинаа шайригддаг нэгнийг *Шайриг Дууяа*, шүлсээ хаа хамаагүй хаяж явдаг дадал зуршлаар нь *Пулемёт Санжаа*, унгараг нэгнийг *Дарвик* Баатар, юм л бол уйлдаг, уйланхай хүүхдийг *Мэлмэрээ*, нойр ихтэй, унтаж л байдаг охиноо *Унтаахай* Халиунаа, том болтлоо соосго хөхсөн *охиныг Соосго* Айнаа, гэрийнхнийхээ хувцасыг бараг хиргүй ч хамаад угаачихдаг охиноо *Угаалгын машин* гэх мэтээр хочилсон жишээ бидний судалгаанд бүртгэгдсэн юм.

Чадвартай нь холбоотой хоч нэр *Тухайн хүний чадварыг үнэлж өгсөн хоч нэр нь ихэвчлэн эерэг үнэлэмжтэй, бахархсан өнгө аястай байдаг*. Тухайлбал,

- *Адуу Цогт* (100 м-ийн гүйлтэд маш хурдан гүйдэг)
- *Бинго Золоо* (Тест бөглөхдөө байнга таадаг ч онодог)
- *Босоо Самдан* (Улсын аварга, унаа багатай)
- *Бренд Ганаа* (Ангийн сурагчдаас хичээлдээ хамгийн сайн нь)
- *Гавал Батболд* (Тоо бодохдоо гаргууд чадвартай)



- *Дүүгүүр Болдбаатар* (Улсын начин, дүүгүүрдэх мэхийг гарамгай сайн хийдэг)
- *Зохиолч* - Осорцэрэн (Толгой холбож ярьдаг, шүлэг бичдэг)
- *Ирээдүйтэй залуу* (Юм юманд чадварлаг, авьяастай, дөлгөөн зантай)
- *Маарамба- Норжин* (Ажлынхныхаа тариаг хийчихдэг, бариа хийж өгдөг)
- *Майкл Джордон* (Сагс сайн тоглодог)
- *Мундаг Наваан* (Улсын заан)
- *Найдвар Болдоо* (Ангийнхандаа хичээлээ хуулуулдаг)
- *Өмсдөг Дамдиндорж* – (Ц.Дамдиндорж (Улсын заан). Өмсөх мэхийг төгс сайн хийдэг байсан)
- *Тавхай Энхцэцэг* (*Хурдан гүйдэг*)
- *Тооны машин* - Булган (Цээжээрээ тоо сайн боддог)
- *Төмөр дэгээ* (Ш.Төмөрбаатар, улсын арслан, голдуу дэгээ ороох мэхээр давдаг)
- *Универсаль Буянтогтох* (Гарын уртай, юм юм оролддог, эм тан, судас барьдаг)
- *Хатуу хар* (Д.Лхагвасүрэн, улсын заан, хоёр шуундаа бяргай, гарын хүч ихтэй)
- *Хичээнгүй бичигч Дээгий* (Гоё сайхан бичдэг)
- *Хурдан гүйдэлтийнхэн* (Гэрээрээ хурдан)
- *Хурдан хар* (Аймаг, сургуулийн гүйлтийн тэмцээнд байнга түрүүлдэг) гэх мэтээр хочлон нэрлэсэн байна.

6. Хамаа харьяа, ажил төрөлтэй холбоотой хоч нэр

- Хамаа харьяа заасан хоч нэр
Өнчин цагаан (Амьдарч байгаа байраар нь), *Хавцалын Мягмар* (Нутагладаг газрынх нь байгалийн тогтоцоор), *Цагаач Самдан* (Уугуул иргэн бус, шилжиж ирсэн), *Ширхэгмаа* (Ангийн ганц эрэгтэй оюутан) гэх мэт зөвхөн хамаа харьяа заасан утгатай хоч нэр байна.
- Харин оршин байгаа газар, нутаг, үндсэн захиргааг заасан нэр нь тухайн хүний хочтой нийлж нийлмэл хоч нэр үүсгэсэн байдаг.
Тухайлбал, Хамаа харьяа, гадаад төрх байдлаар нь давхар хочилсон:

- *Алтайн арзгар* (Энхбат, оюутан)

- *Архангайн Эрэн хавиргат* (Төрбат, улсын арслан)
- *Булганы булчирхай шар* (Шинээ, оюутан)
- *Гандангийн бүрхэг* (Намжилваанчиг, улсын арслан, хараа муутай бөх байсан)
- *Дорнодын Гулзгай* (Дамчаа, улсын арслан)
- *Дорнодын Хумбаан хар* (Л. Балсан, улсын арслан)
- *Заалны загал толгойт* (Давааням, биеийн тамирын багш)
- *Нисэхийн шар Арилдий* (Улсын заан)
- *Тээхийн хар* (Бямбаа, улсын заан)
- *Увсын долоон хар* (Ж.Хайдав, улсын арслан)
- *Ховдын жижиг Ванчинхүү* (Улсын арслан) гэх мэт олон хоч нэр бидний судалгааны санд байна.
- Мөн хамаа харьяа, чадвараар нь давхар хочилсон:
- *Далай вангийн Төмөр дэгээ* – Ш.Төмөрбаатар (Улсын арслан)
- *Нисэхийн тавхай Лувсан* (Улсын заан)
- *Сэлэнгийн Дэгээ* – Батмөнх (Улсын начин)
- *Эрдэнэдүүрэгч сангийн Босоо Шагдар*
- Хамаа харьяа, эд эдлэл, гадаад төрх байдлаар нь давхар хочилсон:
- *Ховдын Хадагт хар* (Д.Рэнцэндорж, улсын заан, хүзүүндээ хадагтай барилддаг, хар царайтай хүн байсан)
- *Баянхонгорын том гуталт* (П.Нямжанцан начин, 1959 онд Монголын залуучууд оюутны анхдугаар их наадамд ирж барилдахдаа татгардуу ногоон зодогтой, гарын эсгийгээр хийсэн далбагардуу оймстой, том монгол гутал өмссөн байсан тул олноос ийм хоч нэр хүртсэн байдаг)
- Хамаа харьяа, дадал зуршлаар нь давхар хочилсон:
- *Завханы Хөндлөн* (Д.Сундуйжав, улсын заан, барилдахдаа хөндлөн зогсож өрдөг байсан) гэх мэт хоч нэр байгаа бөгөөд бөхийн хоч нэрийн хувьд хамаа харьяа, чадвар, дадал зуршлаар нь хочлохдоо тухайн бөхөөр бахадсан олны сэтгэлийг илтгэсэн байдаг.
- Ажил төрлийн холбоотой хоч нэр: Тухайн хүний эрхэлж буй ажил төрлийг үндэс болгон өгсөн: *Буур Ганбаа* (Тэмээ хариулдаг), *Кукуру Болдоо*

(Өндөг зардаг), *Мал Очир* ("Монгол мал" хөтөлбөр батлуулсан, сонгуульд нэр дэвшихдээ хуц, ухна тараасан), *Мэ Болдоо* (Мэдрэлийн эмч), *Ноосны Пүрэвсүрэн* (Ноосон эдлэл хийдэг), *Ойн Пүүжээ* (байгалийн байцаагч), *Өлөнгийн Болдоо* (Өлөн авдаг), *Өргөмжлөл Ганболд* (хэвлэх үйлдвэрт нь байгууллагууд өргөмжлөл их хийлгэдэг), *Simens Батбаяр* (Simens маркийн гар утас дагнан засдаг), *Тугалчин банди* (Пүрэвхүү - Үхэр хариулдаг, жижиг биетэй), *Турба - Болд-Эрдэнэ* (Төмрөөр юм хийдэг), *Хавай - Энхболд* (Хавдрын эмч), *Хог Самбуу* (Хог ачдаг машины жолооч), *Хуушуур Догоо* (Хуушуур зардаг), *Хуцны Ганбаа* (Хуц ухна хариулдаг), *Шахаа Ганбаа* (Нэхийний ченж), *Явдаг ТҮЦ* (Гар дээрээс худалдаа эрхлэгчид) гэх мэт хоч нэр байна.

7. Үйл хөдлөлтэй холбоотой хоч нэр

Бидний судалгааны баримт болгож буй 1536 (давхардаагүй тоогоор) хоч нэрийн 33 нь буюу 2.08 % нь үйл хөдлөлөөр нь өгсөн хоч нэр байгаа бөгөөд үүнд: *Гунхалзуур Отгонцэцэг*, *Гулжиг Даваа*, *Гунхдаг Бүжээ*, *Намираа Должоо*, *Ов хавгүй Олдогсүрэн*, *Өрөмний өт Алтанзул*, *Уян Буян* (Бөхийн нэрт дасгалжуулагч, маш уян хөдөлгөөнтэй, уран барилдаантай бөх байсан) гэх мэт үйл хөдлөлийн ерөнхий дүр төрх заасан утгатай; *Годон Дампил* (Улсын арслан Р.Дампил - мэх сайтай, годогносон түргэн хөдөлгөөнтэй бөх байсан), *Гүйдэг Сүрэнжав*, *Гүйдэг хар Базар*, *Дэвхрэг Маань*, *Жийгдэг хорхой*, *Жирийдэг Бабаа*, *Жонжоолой Даваадэлгэр*, *Жороо Энхбаяр*, *Жороо морь*, *Мөөжиг*, *Мэлхий Ойдов*, *Нисдэг Чука*, *Нухуур Дамба*, *Пэд пад Туугий*, *Сунадаг дугуй Батдорж*, *Сүүдэг*, *Такси Лхагваа*, *Тожго Лувсан*, *Тэшиг Байгаль* (Явах нь тэмээ шиг), *Шуурга Бажгаа*, *Шумахар Төвшөө*, *Яст мэлхий гэх мэт явдал, үйл хөдлөл заасан утгатай хоч нэр байна*. Үйл хөдлөлтэй холбоотой хоч нэрийн ихэнх нь тухайн хүнийхээ үйл хөдлөл, явдлыг нь шууд дүрслэн нэрлэсэн байгаа бөгөөд *Өрөмний өт*, *Дэвхрэг Маань*, *Жороо морь*, *Мэлхий Ойдов*, *Такси Лхагваа*,

Тэшиг Байгаль (Явах нь тэмээ шиг), *Шуурга Бажгаа*, *Шумахар Төвшөө*, *Яст мэлхий* гэсэн цөөн хоч нэр нь бусад хүн, юм, үзэгдэлтэй зүйрлэн нэрлэжээ.

Тухайн хүний үйл хөдлөлтэй холбоотой хоч нэр нь хэрэглээ багатай ч өөр утгын ангилалд оруулах боломжгүй, бие даасан шинжтэй байна.

8. Хэл яриа, дуу хоолойны онцлогтой холбоотой хоч нэр

- Хэл ярианы онцлогтой холбоотой хоч нэр *Болжмор* (Болжмор шиг шулганаж ярьдаг), *Бавраа Агваанданзан*, *Гацаа Авид*, *Дүл дал Дэжид*, *Зөөг Чүлтэм*, *Зуудаг Дорж*, *Па па Нацаг* (па па гэж пүлэгнэж ярьдаг), *Пайтан Жамъяншарав*, *Пал пал Батаа*, *Пампаан Жамъяншарав* (Улсын заан), *Паржигнуур*, *Тальтан хэлт Лундаа*, *Хэлгий Намдаг*, *Хэлгүй Даадай*, *Хэлгүй Шуугуур*, *Хэлэмгий Гэрэл*, *Шал пал Нацаг*, *Шулга Алтангэрэл*, *Шулга шар*, *Шулгануур Жамбаа* гэх мэт хоч нэр байгаа бөгөөд энэ нь ихэвчлэн хэл ярианы гажгаар нь шоглож, шоодсон байна
- Дуу хоолойны онцлогтой холбоотой хоч нэр *Аялгуу Нацаг*, *Бүдүүн дуут Цэдэндамбаа*, *Дүнгэнэдэг хар*, *Жонгиноо Болроо*, *Сөөнгө Пүрэвсүрэн*, *Трактор Отгонбаатар* (трактор асч байгаа юм шиг инээдэг), *Ход ход*, *Хөх түрүү Энхбаатар* (дүнгэнэдэг), *Царцаа* (царцаа шиг "цгэ" гэж дуугарч ярьдаг), *Цээлхэн Надмид*, *Чахраа Буяа*, *Төмөр хоолойт Мягмар* (Улсын нэрт засуул), *Шингэн дуут* гэх мэт хоч нэр байгаа бөгөөд дуу хоолойн бусдаас ялгарах шинжийг заахын зэрэгцээ *Аялгуу*, *Цээлхэн* гэх мэтээр тухайн хүний дуу хоолойгоор бахархсан, *Ход ход* хэмээн өхөөрдсөн, *Сөөнгө*, *Трактор*, *Дүнгэнэдэг хар*, *Жонгиноо*, *Шингэн дуут* гэх мэтээр шоолсон, *Хөх түрүү*, *Чахраа* гэх мэтээр дургүйцсэн утгын өнгө аясыг илэрхийлсэн байна.

9. Эд эдлэл, бэл бэнчинтэй холбоотой хоч нэр

Монгол хүний хоч нэрд өмсөж зүүдэг хувцас хунар, эдэлж хэрэглэдэг эд эдлэл, бэл,



бэнчингээр нь нэрлэсэн хоч нэр байна.


Тухайлбал, Жаргалан (Баянхонгор, Баацагаан сум) гэдэг охинд шар хослол өмссөн нэг удаагийн тохиолдлоор *Тором* хэмээх хоч нэр өгсөн; аалзны дүрстэй баллуур хэрэглэж, ангидаа баллуураараа тоглож суудаг Даваа (Дундговь, Дэрэн сум) гэдэг хүүд ангийнхан нь *Аалз Даваа* гэдэг хоч нэр өгсөн, байнга цүнх үүрч, юм бүхэнд данс даваа хөтөлж явдаг Батсайхан (Архангай, Цахир сум) хэмээх багийн даргаа *Хомбого Батсайхан* хэмээн хочилсон, том халхагар дээл өмсөж явдаг Норов (Говь-Алтай, Тонхил) хэмээх эрд *Элбэг Норов*, хүйтэнд ч нимгэн хувцастай явдаг Гунгаа (Архангай, Чулуут) хэмээх хүүд *Ядуу хар*, ногоон эрэн хувцас өмссөнөөр нь Тулгаа хэмээх хүүд *Десант Тулгаа*, улаан тууз зүүдэг ангийнхаа охинд *Улаан залаат*, улаан малгай өмсөж явдаг Пүрэв өвгөн (Баянхонгор, Байдраг) -д *Улаан малгайт* Пүрвээ, Улаан хүрэн булигааран гуталтай барилддаг байсан улсын заан Б.Жанчивдоржид *Улаан гуталт* гэдэг хоч нэр өгсөн байдаг.

Байнга татдаг тамхиар нь *West Napaа, Camel Баттулга, Наша прима*, эдэлж хэрэглэдэг зүйлээр нь том гинж зүүдэг учир *Гинж Чука*, нүдний шил зүүдэг учир *Очки Жамъянжав, Доктор*, яргай ташуур барьж явдаг учир *Яргай Дорж*, барьдаг гар утас, компьютер хоёр нь хоёул Samsung фирмийнх байснаас *Samsung Тулга* гэх мэтээр хочлон нэрлэсэн байдаг.

Мөн бэл бэнчинтэй нь холбоотой *Баян Бавуу, Баян цагаан* (бэл бэнчин сайтай, цагаан царайтай), *Мөнгөн Балдир* (Улсын заан, цалин цагаан мөнгөн тоногтой эд зүйл голдуу хэрэглэдэг байсан), *Эрийн хуйх* (З.Содномдаржаа, аймгийн заан, хурдан, жороо сайхан морь унадаг, бэл бэнчин сайтай бөх байсан) гэх мэтээр хочилсон байна.

Бүдүүвч 1

Хоч нэрийн ангиллыг схемчлэн харуулбал:



Бидний судалгааны санд буй 1536 хоч нэр (давхардаагүй тоогоор) -ийн 59.2% нь хүний гадаад төрх байдлаар нь, 19.6% нь зан араншингаар нь, 4.3% нь их нэрээс нь үүтгэн, 4.0% нь тохиолдсон явдал, хэлдэг (хэлсэн) үгээр нь, 3.9% нь дадал зуршил, хобби, чадвараар нь, 2.73% нь хамаа харьяа, ажил төрлөөр нь, 2.2% нь хэл яриа, дуу хоолойн онцлогоор нь, 2.0% нь эд эдлэл, бэл бэнчингээр нь тус тус оноож өгсөн байгаа нь монголчууд ихэвчлэн гадаад төрх байдал, зан араншингийн бусдаас ялгарах онцлогоор нь хочлон нэрлэдэг гэх үндэстэй байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Бадамдорж, Д. (2006). *Монгол хэлний үгсийн сангийн утга зүй*. Улаанбаатар
- Бадамноров, Д. (2000). *Монгол хүний хоч нэрийн утгын тухай*. МУИС-ийн Ховд дахь салбар сургууль. *Эрдэм шинжилгээний ойллого, II боть XVI дэвтэр*. Улаанбаатар
- Баянсан, Ж. (1996). Зүйрлэл бол танин мэдэхүй, сэтгэлгээний онцлогийн тусгал болох нь. МУИС, МСДС, ЭШБ, Улаанбаатар
- Бямбасан, П. (1969). Оноосон нэрийн тухай. *Хэл зохиол судла, II боть*. Улаанбаатар
- Горбаневский, М. (1987). *В мире имен и названий*. Москва
- Даваасүрэн, Б. (2009). *Орчин цагийн монгол хэлний жинхэнэ нэрийн хүншүүлсэн утга*, Улаанбаатар
- Жигмэддорж, Э. (2002). Монгол хүний хоч нэрийн түүхэн уламжлал. МУИС, НУФ, Оюутны эрдэм шинжилгээний бичиг. Улаанбаатар
- Мөнх-Амгалан, Ю. (1998). *Орчин цагийн монгол хэлний баймжийн ай*. Улаанбаатар
- Нансалмаа, Н. (1997). *Орос монгол хэлний амьтны нэрийн хүншсэн утгыг утга зүй, толь зүйн хүрээнд судалсан нь*. Улаанбаатар
- Нансалмаа, Н. (2004). Орчин цагийн монгол хэлний хоч нэрийн бүтэц, утга зүйн онцлог. МУИС. МХСС. *Монгол судлал. ЭШБ, 23-р боть. 9-р дэвтэр*. Улаанбаатар
- Нансалмаа, Н. (2011). *Үг: утга хэрэглээ*. Улаанбаатар
- Пагва, Т. (2001). *Хэлиинжлэлийн асуудлууд, дэд дэвтэр*. Улаанбаатар
- Сэржээ, Ж., Сувд. Ц., ба бус. (2010). Орчин цагийн монгол хэлний оноосон нэрээс оноосон нэр дахин үүсэх зүй тогтол. МУИС. ЭШБ. Боть XXXI (328). Улаанбаатар
- Төмөрцэрэн, Ж. (1974). *Монгол хэлний үгсийн сангийн судлал*. Улаанбаатар
- Хай-Ин-Хуа. (Насан-Урт). (2010). Монгол хэлний жинхэнэ нэрийн утгын ангиллын чухал чанар. МУИС. МХСС, *Монгол судлал, ЭШБ, Боть XXXI (328)*. Улаанбаатар
- Халтар, Т., Лхагва, Х. (2007). *Хүчтэний өлгий-Арын хангайн бөхчүүд*. Улаанбаатар
- Хүрэлбаатар, Н. (2006). *Зөв нэр*. Улаанбаатар
- Шулунова, В.Л. (1985). *Прозвища в антропонимии бурят*. Улан-Удэ.
- Энхбат, Д. (2004). *Хүмүүний зохист нэр*. Улаанбаатар